

4

Стратегийн ач холбогдол бүхий гадаадын нийлүүлэгчидтэй хамтран ажиллах тухай бодлого

УДИРТГАЛ 48

- | | | |
|----|--------------------------------|----|
| 1. | Бодлогын Баримт Бичгийн Дугаар | 48 |
| 2. | Зорилго | 48 |
| 3. | Хамрах Хүрээ | 49 |
| 4. | Мөрдөж эхлэх хугацаа | 49 |
| 5. | Бүрэн эрх, удирдлага | 49 |

БОДЛОГО 49

- | | | |
|----|--|----|
| 1. | Голлох томоохон Нийлүүлэгч/Гүйцэтгэгчийн Үүрэг | 49 |
| 2. | Харилцан Ойлголцлын Санамж Бичиг (ХОСБ) | 50 |
| 3. | Нийлүүлэгчийг үнэлэх, ажлын гүйцэтгэлд нь хяналт тавих | 50 |

Удиртгал

1. Бодлогын Баримт Бичгийн Дугаар

Энэхүү бодлогын баримт бичгийг ХААБ-05: **Стратегийн ач холбогдол бүхий гадаадын нийлүүлэгчидтэй хамтран ажиллах тухай бодлого** гэж нэрлэнэ.

2. Зорилго

Энэхүү бодлогоор гадаадын томоохон нийлүүлэгчдийг дотоодын аж ахуйн нэгжүүдтэй үр ашигтай хамтран ажиллах буюу орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр түүнчлэн Монгол Улсад өгөх төслийн үр өгөөжийг оновчтой болгох, нэмэгдүүлэх хамтын үүрэг амлалт авч ажиллах хөтөлбөрийг тодорхойлно. Оюу Толгой ХХК нь 2011 оны 12 дугаар сарын 1 – ний өдрөөс хойш байгуулсан дотоодын хөгжилд хувь нэмэр бүхий гэрээний хувьд хамгийн тэргүүний 10 голлох нийлүүлэгчдийг онцлон анхаарлаа хандуулна.

Мөн энэхүү баримт бичигт дараах ойлголтуудын талаар тодорхой тусгасан болно. Үүнд:

- Орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр, Монгол Улсад өгөх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд нийлүүлэгчдийн хүлээх үүрэг, хариуцлага;
- Гэрээний үүргийн биелэлтийг хангуулах зорилгоор Оюу Толгой ХХК-ийн нийлүүлэгчдийг үнэлэх болон ажлын гүйцэтгэлд тавих хяналт зэрэг болно.

Зураг 1-д харуулснаар, ХААБ 05: Стратегийн ач холбогдол бүхий гадаадын нийлүүлэгчидтэй хамтран ажиллах тухай бодлого нь Оюу Толгой ХХК-ийн Худалдан авах ажиллагаанд баримтлах үндсэн 8 бодлогын нэг нь юм.

Зураг 1: Оюу Толгой ХХК-ийн худалдан авах ажиллагааг удирдан зохицуулах үндсэн бодлогын баримт бичгүүд



3. Хамрах Хүрээ

Энэхүү бодлогын баримт бичгийг дараах хүмүүс даган мөрдөнө. Үүнд:

- Оюу Толгой ХХК-ийн Худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжийн бүх ажилтан;
- Оюу Толгой ХХК-ийн стратегийн ач холбогдол бүхий гадаадын нийлүүлэгчид

4. Мөрдөж эхлэх хугацаа

Энэхүү шинэчлэн найруулсан бодлогыг 2012 оны 11-р сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

5. Бүрэн эрх, удирдлага

Энэхүү шинэчлэн найруулсан бодлогын баримт бичгийг Оюу Толгой ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2012 оны 11-р сарын 20-ны өдөр батлав.

Энэхүү баримт бичгийг жил бүр эсхүл шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хянан засварлана.

Оюу Толгой ХХК-ийн Хангамж, Дэд бүтцийн хөгжил хариуцсан Дэд ерөнхийлөгч нь тус бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хариуцна. Энэхүү бодлогод өөрчлөлт оруулах аливаа санал хүсэлтийг дээрх албан тушаалтанд гаргах бөгөөд тэрээр зохих ёсоор хянан, батална.

Бодлого

1. Голлох томоохон Нийлүүлэгч / Гүйцэтгэгчийн Үүрэг

- Одоогийн хамтран ажиллаж буй гадаадын томоохон нийлүүлэгчид нь Оюу Толгой ХХК-ийг Хөрөнгө Оруулалтын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх үүднээс орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр болон дотоодын аж ахуй нэгжүүдийн хувьд бизнесийн боломжуудыг нь тодорхойлох замаар тэдний оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн Харилцан Ойлголцлын Санамж Бичиг (ХОСБ)-ийг Оюу Толгой ХХК-тай байгуулна.
- Бидэнтэй ажиллаж байгаа гадаадын нийлүүлэгчид нь дотоодын нийлүүлэгчидтэй (тогтоосон зорилго болон босго үнийн дагуу) хамтран ажиллах үүрэг хүлээх ба үүний өгөөж, үр ашгийн талаар ойлгосон байвал зохино.
- Эдгээр төлөвлөсөн зорилтоо давуулан биелүүлсэн сайн түншлэгч нийлүүлэгчдийн хувьд гэрээний хугацааг нь цаашид сунгах болон давуу эрхтэй нийлүүлэгчийн зэрэглэл/статус/-тэй болгох зэргээр урамшуулж болно.
- Шинээр нийлүүлэгчдийг энэхүү үйл ажиллагаанд татан оролцуулахад

дотоодын аж ахуйн нэгжүүдийн оролцоог нэмэгдүүлэх үүргийг Оюу Толгой ХХК-ийн Гэрээний Ерөнхий Нөхцөл-д тусгайлан заасан хуваарийн дагуу оруулах бөгөөд энэ нь сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлт болон Санал ирүүлэх урилгын үйл явцын нэг хэсэг нь юм.

2. Харилцан Ойлголцлын Санамж Бичиг (ХОСБ)

- Орон нутгийн хөгжилд хувь нэмэр түлхүү оруулах, дотоодын аж ахуйн нэгжүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр Оюу Толгой ХХК-ийн зарцуулалтын буюу худалдан авалтын үнийн дүнгээрээ хамгийн өндөр байх гадаадын 10 голлох нийлүүлэгчийг сонгон, тэдэнтэй байгуулах ХОСБ-т холбогдох зорилго болон босго үнийн дүнгээс хамааран тэдний хүлээх үүрэг хариуцлагын талаар тодорхой тусгана. Үүнд дор дурдсан зорилгыг хэрэгжүүлэх ба мөн үүгээр үл хязгаарлагдана:
 1. Сургалт
 2. Дадлагажуулах сургалт
 3. Тэтгэлэгт хөтөлбөр
 4. Дотоодын аж ахуй нэгжүүдэд зориулсан сургалт/зөвлөгөөний хөтөлбөр
 5. Монгол Улсын ажиллах хүч
 6. Туслан гүйцэтгэгч ажиллуулах үүрэг
 7. Монгол Улсад оруулах хөрөнгө оруулалт
 8. Технологи дамжуулах боломж
 9. Хамтарсан түншлэл
 10. Албан ёсны төлөөлөгчийн гэрээ

3. Нийлүүлэгчийг үнэлэх, ажлын гүйцэтгэлд нь хяналт тавих

- Энэ арга барил нь худалдан авалтын дүнгээрээ тэргүүлэх 10 голлох нийлүүлэгчийн хувьд гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, нөөц бололцоогоо дайчлан үүрэг хариуцлагаа хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих үүднээс гэрээний оновчтой удирдлагыг бий болгохыг шаардана.
- Орон нутгийн хөгжилд хувь нэмэр түлхүү оруулах, дотоодын аж ахуй нэгжүүдийн оролцоог хангах үүрэг амлалтаа Оюу Толгой ХХК-ийн өмнө дээрх үүргээ биелүүлж буй бусад нийлүүлэгчтэй харьцуулахад хангалтгүй буюу биелүүлэхгүй байгаа нийлүүлэгчдээс аль болох татгалзана.